



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 11 сарын 03 өдөр

Дугаар 542

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах, үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7.1 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Баруун бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч ашиглаж болох 13 нэрийн нийт 248,770,411.54 (хоёр зуун дөчин найман сая долоон зуун далан мянга дөрвөн зуун арван нэгэн төгрөг тавин дөрвөн мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 128,860,000.00 (нэг зуун хорин найман сая найман зуун жаран мянган) төгрөгөөр шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Насантогтох, “Баруун бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Р.Нямтуул нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Компанийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасны дагуу хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2020 оны 11 дугаар сарын 25-ны өдрийн
542 дугаар тогтоолын хавсралт

"БАНУН БҮСҮЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
ҮЛДЭХ ӨРТӨГГҮЙ ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТЫН ХУГАЦААГ СУНГАХ, ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчилсэн үнэ (төгрөг)	Ашиглалтын хугацаа сунгах (жил)
1	Цахилгаан тоолуур А1805	2011-01-03	ш	1	1,772,727.27	880,000.00	4 жил
2	Цахилгаан тоолуур	2010-08-06	ш	1	1,772,727.27	880,000.00	4 жил
3	Аваарын бичлэг хийх тоноглол	2009-02-12	ш	1	43,000,000.00	21,500,000.00	5 жил
4	Аккумулятор цэнэглэгч gzw-200	2009-06-12	ш	1	29,483,000.00	14,000,000.00	5 жил
5	Аккумулятор цэнэглэгч g70w -100	2008-12-14	ш	1	19,360,000.00	8,500,000.00	5 жил
6	Худаг Баян - өлгий	1997-04-16	ш	1	6,600,000.00	5,300,000.00	10 жил
7	Худаг Мянгад	1997-09-13	ш	1	10,191,827.00	8,000,000.00	10 жил
8	Худаг Улаангом дэд станц	1997-04-16	ш	1	3,880,000.00	3,100,000.00	10 жил
9	Худаг ББЭХС	1997-04-16	ш	1	3,330,000.00	2,700,000.00	10 жил
10	Автомашинны чиргүүл Зил 130	2011-02-02	ш	1	4,273,500.00	2,700,000.00	6 жил
11	Автомашин МТО	2011-02-02	ш	1	33,000,000.00	16,000,000.00	6 жил
12	Автомашин кран / жижиг /	2012-02-27	ш	1	75,350,000.00	37,000,000.00	3 жил
13	Автомашин фураган УАЗ	2011-05-03	ш	1	16,756,630.00	8,300,000.00	2 жил
					248,770,411.54	128,860,000.00	-
Нийт дүн					(хоёр зуун дөчин найман сая долоон зуун далан долоон мянга дөрвөн зуун арван нэгэн төгрөг тавин дөрвөн мөнгө)	(нэг зуун хорин найман сая найман зуун жаран мянга)	-